



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2016

2012-2013 оны хичээлийн жилд төгсөгчдийн хөдөлмөр
эрхлэлтийн мөшгих судалгаа 3 дахь жилдээ

Улаанбаатар хот
2017 он

Хаяг: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт

Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо

Чингисийн өргөн чөлөө,

Хөдөлмөрийн ордон, 5 давхар

Факс:

Утас: 77121286

Вэб хуудас: www.rilsp.gov.mn

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2016

2012-2013 оны хичээлийн жилд төгсөгчдийн
хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгаа

“Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа” –г анх 2014 онд хийсэн бөгөөд судалгаанд 2012-2013 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллеж болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгссөн 2000 төгсөгч хамрагдсан. Энэ удаагийн судалгаа нь 2015 онд судалгаанд хамрагдсан төгсөгчдийг 2016 онд дахин судалгаанд хамруулж 3 жил мөшгөн судалснаараа онцлог юм.”

Тайланг хянасан:

М.Алтансүх	ХНХСИ-ийн Захирал
С.Чулуунцэцэг	ХНХСИ-ийн Тамгын газрын дарга
Б.Цэрэнгаваа	ХНХСИ-ийн ХЭБССекторын эрхлэгч

Мэдээллийг боловсруулсан:

Д.Алтангэрэл	ХНХСИ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны секторын Эрдэм шинжилгээний ажилтан
--------------	--

Хэвлэлд бэлтгэсэн:

Хэвлэсэн тоо: 300 хувь

Цаасны хэмжээ: В5

.....ХЭВЛЭВ

Улаанбаатар хот 2017 он.

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ/ ОРШИЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА / СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ/

- 1.1 Судалгааны зорилго, зорилт
- 1.2 Судалгааны хамрах хүрээ
- 1.3 Судалгааны түүвэр, аргачлал
- 1.4 Судалгааны мэдээлэл цуглуулалт
- 1.5 Судалгааны зохион байгуулалт
- 1.6 Судалгааны ойлголт, тодорхойлолт

БҮЛЭГ 2. ТӨГСӨГЧДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- 2.1 Төгсөгчдийн хүн ам зүйн бүтэц
- 2.2 Төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийн байдал

БҮЛЭГ 3. ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- 3.1 Хөдөлмөр эрхэлдэг төгсөгчдийн ажлын байрны төлөв байдал, онцлог, шалтгаан
 - Давхар хөдөлмөр эрхлэлт
- 3.2 Ажилгүй байгаа төгсөгчид ба эдийн засгийн идэвхигүй байдал

БҮЛЭГ 4. СУРГАЛТАНД ХАМРАГДСАН БАЙДАЛ

БҮЛЭГ 5. ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

ДҮГНЭЛТ

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

ХАВСРАЛТЫН ХҮСНЭГТ

ӨМНӨХ ҮГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа” нь мөшгөх судалгааны арга, аргачлалын дагуу зохион байгуулагддаг, үндэсний хэмжээнд төлөөлөх чадвар бүхий томоохон түүвэр судалгаа билээ. Энэ удаагийн судалгаанд 2012/2013 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллеж болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгчдийг гурав дах жилдээ мөшгөн, судалгаанд хамрууллаа.

Судалгааны зорилго нь төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, ажлын байранд зуучлагдаж буй хэлбэр, хугацаа, ур чадварын нийцэл, түүнчлэн ажлын байранд тулгарч буй болон ажилгүй байгаа шалтгаан зэргийг илрүүлэн, салбарын бодлого боловсруулагчид, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын шийдвэр гаргагчид, судлаачдыг тоон мэдээллээр хангахад чиглэгддэг.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг ажил мэргэжлийн түвшинд судлах явдал нь бодлого боловсруулахад ихээхэн ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн зах зээлд бэлэн буй ажлын байрны шаардлагад сургалтын байгууллагаас нийлүүлэгдэж байгаа мэргэжилтэй шинэ ажилтнуудын ур чадвар нийцэж буй эсэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, хэлбэр, тэдний хэтийн төлөвлөгөө зэрэг асуудлыг тоон болон чанарын үзүүлэлтүүдээр дамжуулан судалж, түүнийг хэрэглэгчидэд хүргэж, бодлогод нөлөөлж байгаа нь уг судалгааны ач холбогдол оршиж байна.

Та бүхэн судалгааны үр дүнтэй танилцан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлалтай, мөн шинжилгээтэй холбоотой санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллахыг хүсье.

ЗАХИРАЛ

М.АЛТАНСҮХ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны зорилго нь дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн мэргэжил, ур чадварын хөгжил болон хөдөлмөр эрхлэлтийн байдал, ажлын байранд зуучлагдаж буй хэлбэр, хугацаа, ур чадварын нийцэл, түүнчлэн ажлын байранд тулгарч буй болон ажилгүй байгаа шалтгаан зэргийг илрүүлэн, салбарын бодлого боловсруулагчид, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын шийдвэр гаргагчид, судлаачдыг тоон мэдээллээр хангахад оршино. Энэхүү мөшгөх судалгаа нь олон улсад түгээмэл хэрэглэгддэг бөгөөд тодорхой арга, аргачлалд тулгуурладаг юм. Бид тус аргачлалын дагуу 2014 онд 2012-2013 оны хичээлийн жилд ИДСК төгссөн 37243 төгсөгчдөөс ИДС-ийн 22 мэргэжлийн чиглэлээр 1232 төгсөгчийг, МБСБ төгссөн 23393 төгсөгчдөөс МБСБ-ийн 11 мэргэжлийн чиглэлээр 768 төгсөгчийг түүвэрлэн, судалгаанд хамруулсан ба судалгаанд хамрагдсан 2000 төгсөгчийг 2015, 2016 онуудад мөшгөн судалснаараа онцлогтой юм. Төгсөгчдийн хаяг, утасны дугаар өөрчлөгдөж холбоо тогтоох боломжгүй болсон, гадаад явсан, судалгаа өгөхөөс татгалзсаны улмаас зорилтот түүврийн хэмжээ 2014-2016 онд 20 хувиар буурсан.

Энэ удаагийн судалгаанд төгсөгчдийн боловсрол, гэр бүлийн байдал, хөдөлмөр эрхлэлтэд гарсан өөрчлөлт, цаашдын зорилготой холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл, дахин суралцсан эсэх, ажил хайж байгаа болон ажилгүй байгаа төгсөгчдийн шалтгаан зэргийг тодрууллаа.

Төгсөгчдийн 43.9 хувь нь эрэгтэй, 56.1 хувь нь эмэгтэй байсан ба дундаж нас 26 байна. Төгсөгчид гэрлэлтийн байдлаар нийт төгсөгчдийн 45.7 хувь нь гэрлээгүй, 35.5 хувь нь батлуулсан гэр бүлтэй, 18.9 хувь нь батлуулаагүй гэр бүлтэй байна.

Төгсөгчдийн 61.6 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд тус үзүүлэлт нь өмнөх оныхоос буурсан байна. Эрэгтэй нийт төгсөгчдийн 69.0 хувь нь, эмэгтэй төгсөгчдийн 56.6 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Мөн 2015 онд ажилгүй байсан төгсөгчдийн 5.4 хувь нь, ажилтай байсан төгсөгчдийн 52.3 хувь нь 2016 онд хөдөлмөр эрхэлж байна. Харин 2015 онд ажилтай байсан төгсөгчдийн 12.4 хувь нь ажилгүй байна.

Хөдөлмөр эрхэлж байгаа ИДС төгсөгчдийн 10 төгсөгч тутмын 9 нь, МБСБ төгсөгчдийн 10 төгсөгч тутмын 7 нь байнгын ажлын байранд ажиллаж байгаа бол 10 төгсөгч тутмын 6 нь Улаанбаатар хотод хөдөлмөр эрхэлж байна.

Хөдөлмөр эрхэлж байгаа ИДС төгсөгчдийн 93.2 хувь нь, МБСБ төгсөгчдийн 75.1 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлдөг бол хувь хүний орлогын албан татварыг 83.2 хувь нь төлдөг, 16.8 хувь нь төлдөггүй байна.

Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн 6.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж байна. Тэдгээр төгсөгчдийн 14.0 хувь нь мэргэжлийн ажил олдохгүй, 12.1 хувь нь цалин, орлого амьжиргаанд хүрэлцэхгүй байсан, 9.4 хувь нь гэр бүлийн бизнес, аж ахуй эрхэлдэг зэрэг шалтгааны улмаас хувиараа хөдөлмөр эрхлэх болсон гэсэн. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 21.2 хувь нь цалин хөлстэй ажилтнаас илүү орлого олдог гэж өөрсдийгөө тодорхойлсон байна. Цалин хөлстэй ажилтны хувьд 81.4 хувь нь хөдөлмөрийн гэрээтэй, 18.6 хувь нь хөдөлмөрийн гэрээгүй байдаг ба хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй төгсөгчдийн 50.5 хувь нь хугацаатай, 49.5 хувь нь хугацаагүй гэрээ байгуулан ажиллаж байна. Хөдөлмөрийн гэрээгүй ажиллаж байгаа төгсөгчдийн дундаж цалин 579.2 мянга байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 7 хоногийн ажлын дундаж өдөр нь энгийн ажлын цагийн горимын дагуу бөгөөд харин 12.1 хувь нь 7 хоногийн 7 өдөр ажиллаж байна. Сургуулийн төрлөөр нь тодруулбал ИДС төгсөгчдийн 7.8 хувь нь, МБСБ төгсөгчдийн 21.8 хувь нь 7 хоногийн 7 өдөр ажилладаг гэжээ.

2016 оны судалгаанд хамрагдсан төгсөгчдийн сарын дундаж цалингийн хэмжээ нь 640.2 мянган төгрөг гэсэн. Үндэсний статистикийн хорооны 2016 оны 3-р улирлын мэдээгээр ажиллагчдын дундаж цалин 884.3¹ мянган төгрөг байгаа бөгөөд төгсөгчдийн дундаж цалин, улсын дундаж цалинтай харьцуулахад нэлээд бага байна.

Сүүлийн гурван жилд давтан явуулсан судалгааны үр дүнгээс харахад ажлын байранд тавигдаж буй ажил үүргийн шаардлага, боловсролын түвшингийн тохиромжтой байдлыг харахад жилд дундажаар 70 гаруй хувь нь нийцтэй байна. Үлдсэн 30 хувьд нь боловсролын түвшингээс хамаарсан ажил үүргийн үл нийцэл байгаа харагдаж байна. Харин төгсөгчдийн 10 гаруй хувь нь ажил үүргийн шаардлага ур чадвараас нь өндөр ажил үүргийн шаардлагатай ажил хийж байна. Цаашид ямар мэргэжлээр төгссөн төгсөгчдөд ур чадварын зөрүү их гарч байгааг нарийвчлан судлах шаардлагатай байна.

2014-2016 оны судалгааны үр дүнгээс харахад гадаад хэлний мэдлэг нь хамгийн их тулгарч буй ур чадварын хомсдолын нэг бөгөөд түүний хэрэгцээ шаардлага жил ирэх тутам нэмэгддэг байна. Түүнчлэн төгсөгчдөд тулгарч буй ур чадварын хомсдолд мэргэжлийн ур чадвар, багаар ажиллах чадвар зэрэг нь нилээдгүй хувийг эзэлсээр байна. Харин шинжлэх ухаан технологийн мэдлэг, мэдээллийн технологийг ашиглах, эзэмших зэрэг ур чадварууд нь ажлын байранд гарсан эхний жил тодорхой хувийг эзэлдэг ч, хугацаа өнгөрөх тусам дутагдах ур чадварт орох хувь нь багасч байна.

Гурван оны судалгаагаар ажилд ороход хамгийн ихээр нөлөөлдөг хүчин зүйл нь эзэмшсэн мэргэжил, ярилцлагын ур чадвар, хувийн зан чанар, төгссөн сургууль, сурлагын дүн, оноо гэсэн хүчин зүйлүүд ажилд ороход түлхүү нөлөөлдөг гэжээ. Төгсөгчдийн хувьд 10 хүн тутмын 6 нь эзэмшсэн мэргэжлээрээ ажилладаг байна. Мэргэжлээрээ ажиллаж байгаа ИДС төгсөгчдийн хувьд сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгүүл ба мэдээлэл, биологи, мал эмнэлэг, анагаах ухаан, цагдаа аюулгүй байдлын, МБСБ төгсөгчдийн хувьд захиргаа үйлчилгээний ажилтан, тээвэр зэрэг мэргэжлийн чиглэлүүд зонхилж байна. Харин мэргэжлээрээ төдийлөн ажиллаж чадахгүй байгаа мэргэжлийн чиглэлүүдэд ИДС төгсөгчдийн хувьд нийгмийн халамж, хамгаалал, ХАА, ОАА, ЗАА, хүмүүнлэгийн ухаан, бизнес ба мэдээлэл, МБСБ төгсөгчдийн хувьд ОАА мод боловсруулах салбар, ХАА үйлдвэрлэл, мэдээллийн технологи зэрэг чиглэлүүд байна. Цаашид мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн шалтгааныг нь тодруулан, ХЗЗ-ийн тухайн мэргэжлийн ажлын байрны хомсдол уу, эсхүл төгсөгчийн ур чадварын дутагдал эсэхийг судлах шаардлагатай юм.

Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн бараг 50 хувь нь мэргэжилтэн бүлэгт хамаарагдах ажлын байранд ажиллаж байна. Тодруулбал ИДС төгсөгчдийн 59.6 хувь нь мэргэжилтэн, 10.1 хувь нь худалдаа үйлчилгээний ажилтан бүлэгт хамаарах ажлын байранд ажиллаж байгаа бол, МБСБ төгсөгчдийн 24.9 хувь нь мэргэжилтэн, 24.0 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 21.9 хувь нь худалдаа үйлчилгээний ажилтан бүлэгт хамаарах ажлын байруудад ажиллаж байна.

¹ ҮСХ, МУ-ын нийгэм, эдийн засгийн байдал I-XI сар, аж ахуй нэгж байгууллагын ажиллагчдын нийт цалингийн дундаж 884.3 мянган төгрөг

Төгсөгчдөөс ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллагыг эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 21 салбараар нь тодруулвал 11.5 хувь нь худалдааны, 12.3 хувь нь боловсролын, 9.6 хувь нь эрүүл мэндийн, 9.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 9.1 хувь нь барилгын салбарт тус тус ажиллаж байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн тогтвортой ажиллах эсэх талаар тодруулахад 81.6 хувь нь тогтвортой ажиллана, 18.4 хувь нь ажлын байранд үлдэх сонирхолгүй байгаагаа илэрхийлсэн. Ажлын байрандаа үлдэх сонирхолгүй байгаа төгсөгчдийн шалтгааныг тодруулахад МБСБ төгсөгчдийн хувьд түр ажлын байр, сурах хүсэлтэй, мэргэжлээрээ ажиллах сонирхолтой гэсэн бол, ИДС төгсөгчдийн хувьд илүү хөгжих боломжтой, нөхцөл сайтай ажил хийх, түр ажиллаж байгаа, мэргэжил мэдлэг нь ур чадварт тохирдоггүй зэрэг шалтгаануудыг дурдсан байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдөөс ажлын байрны мэдээллийн эх сурвалжийг тодруулахад нийт төгсөгчдийн 22.7 хувь нь эцэг эх, хамаатан садан, 27.1 хувь нь найзууд, хамт суралцагсад, 21.6 хувь нь сонин ТВ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернет ажлын зараас авсан гэсэн. Өөрөөр хэлбэл ажлын байрны мэдээллийг хувийн харилцаагаар дамжуулан авсан нь нэлээд түгээмэл байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 4.9 хувь нь давхар ажил эрхэлдэг бөгөөд тэдний 69.5 хувь нь ИДС төгсөгч, үлдсэн 30.5 хувь нь МБСБ төгсөгч байна.

2015 онд хөдөлмөр эрхлээгүй байсан ИДС төгсөгчдийн 32.8 хувь нь, МБСБ төгсөгчдийн 41.1 хувь нь 2016 онд ажилгүй хэвээр байна. Харин их дээд сургууль төгсөгчдийн 0.9 хувь нь, МБСБ төгсөгчдийн 2.7 хувь нь дахин суралцаж байна.

2015, 2016 онуудад ажилгүй байгаа төгсөгчдийн ажилгүйдлийн шалтгааныг тодруулбал 39.4 хувь нь жирэмсэн, хүүхэд, өндөр настан асрах, 27.5 хувь нь эзэмшсэн мэргэжилд тохирох ажил олдохгүй гэх мэт шалтгааныг дурдсан байна. Эзэмшсэн мэргэжилд тохирох ажил олдохгүйн улмаас ажилгүй байгаа төгсөгчдийг сургуулийн төрөл болон мэргэжлийн чиглэлээр нь харвал ИДС төгсөгчдийн хувьд бизнесийн удирдлага, багш, боловсрол судлал, хүмүүнлэгийн ухаан, нийгэм, эдийн засаг, хууль эрх зүй, үйлдвэрлэлийн технологи зэрэг мэргэжлийн чиглэлүүд, МБСБ төгсөгчдийн хувьд барилга, барилгын материал үйлдвэрлэл, аж үйлдвэр, ХАА үйлдвэрлэл, геологи, уул уурхай зэрэг мэргэжлийн чиглэлээр төгссөн төгсөгчид нилээдгүй байна.

2015 онд хөдөлмөр эрхэлж байсан, 2016 онд ажилгүй байгаа төгсөгчдийн 69.6 хувь нь хувийн шалтгаанаар, 30.4 хувь нь байгууллагаас хамаарсан шалтгаанаар ажлаас гарчээ. Ажлаас гарсан төгсөгчдийн хувийн шалтгааныг тодруулахад 38.7 хувь нь ар гэрийн шалтгаан болох жирэмсэн, хүүхэд өндөр настан асрах, 10.1 хувь нь хувиараа бизнес эрхлэх, 6.8 хувь нь ажилдаа сэтгэл ханамжгүй байсан гэсэн. Харин байгууллагаас хамаарсан шалтгаан нь 30.4 хувь нь цалин тогтмол олгодоггүй, 16.7 хувь нь түр ажлын байр байсан, 14.4 хувь нь цалин бага, 11.0 хувь нь орон тооны цомхотголд орсон гэсэн.

Ажил хайж байгаа төгсөгчид ажлын байрны сонголт хийхдээ өсөн хөгжих боломж болон ажил мэргэжлийн ирээдүй, цалин, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааг илүү чухалчилж авч үздэг байна. Ажил хайх явцад тулгардаг гол бэрхшээлүүд нь ажлын байрны болон ажлын байрны мэдээллийн хомсдол, ажил олгогч танил тал хардаг зэрэг асуудал байна.

Төгсөгчдийн 25.8 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд хамрагдсан богино болон урт хугацааны сургалтанд хамрагдсан байна. Харин сургалтанд хамрагдагсадын 80.0 хувь нь богино хугацааны, 20.0 хувь нь урт хугацааны буюу мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамрагдсан байна.

Урт хугацааны мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамрагдсан төгсөгчдийг сургалтын төрлөөр нь харвал 54.1 хувь нь магистр, докторын зэргийн сургалт, 30.6 хувь нь мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт, 12.4 хувь нь ИДСК-д бакалаврын зэргийн сургалтанд хамрагджээ. Сургалтад хамрагдагсдын ИДС төгсөгчдийн хувьд 63.7 хувь нь магистр, докторын зэргийн сургалт, 32.3 хувь нь мэргэжил дээшлүүлэх сургалтанд, харин МБСБ төгсөгчдийн хувьд 70.7 хувь нь ИДСК-д бакалаврын зэргийн сургалт, 20.4 хувь нь мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтанд тус тус хамрагджээ. Богино хугацааны сургалтанд хамрагдсан төгсөгчдийг сургалтын төрлөөр нь тодруулбал 75.6 хувь нь ур чадвараа нэмэгдүүлэх сургалт, 13.2 хувь нь гадаад хэлний сургалтанд хамрагджээ.

Дахин суралцаж байгаа төгсөгчдийн 6.0 хувь нь өмнөх эзэмшсэн мэргэжлээсээ өөр мэргэжлээр сурч байна. ИДС төгсөгчдийн 24.5 хувь нь огт өөр мэргэжлээр суралцаж байгаа бол МБСБ төгсөгчдийн хувьд 69.6 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ үргэлжлүүлэн, 30.4 хувь нь огт өөр мэргэжлээр бакалаврын хөтөлбөрт суралцаж байна.

Төгсөгчдийн ирээдүйн хүлээлтийн талаар тодруулахад 30.0 гаруй хувь нь цаашид суралцах, 20.9 хувь нь тодорхой төлөвлөгөө байхгүй, 22.2 хувь нь ажилд орох, ажлаа өөрчлөх төлөвлөгөөтэй гэжээ. Суралцах төлөвлөгөөтэй байгаа төгсөгчдийн 32.1 хувь нь магистр, докторын зэргийн сургалтанд, 27.6 хувь нь дотоодын их дээд сургуульд элсэн суралцах, 16.8 хувь нь одоо суралцаж буй сургуулиа үргэлжлүүлэн суралцах төлөвлөгөөтэй байна.

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эх олонлогийн ерөнхий мэдээлэл	10
Хүснэгт 2. Түүврийн хэмжээг тодорхойлсон байдал	11
Хүснэгт 3. Түүврийн хэмжээг хуваарилсан байдал	11
Хүснэгт 4. 2014-2016 онд судалгаанд хамрагдсан байдал	11
Хүснэгт 5. ИДС төгсөгчид /мэргэжлийн чиглэлээр/.....	16
Хүснэгт 6. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн статус, оноор.....	20
Хүснэгт 7. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 7 хоногийн ажлын өдөр, цаг /сургуулийн төрлөөр/.....	22
Хүснэгт 8. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн сарын дундаж цалингийн хэмжээ/ он, сургуулийн төрлөөр/.....	22
Хүснэгт 9. Боловсролын түвшин, ажил үүргийн нийцтэй байдал, оноор	23
Хүснэгт 10. Ажил үүргийн шаардлага, ур чадварын нийцтэй байдал /Он, сургуулийн төрөл/ ..	23
Хүснэгт 11. Давхар хөдөлмөр эрхэлдэг төгсөгчдийн ажлын байрны хэлбэр /сургуулийн төрөл/	29
Хүснэгт 12. Ажлын байрны сонголт хийхэд чухалчилдаг зүйлс /сургуулийн төрлөөр/.....	33
Зураг 1. Төгсөгчдийн хүн ам зүйн үзүүлэлт	15
Зураг 2. Өрхийн сарын дундаж орлого	16
Зураг 4. 2015 – 2016 онд гарсан хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт	18
Зураг 5. Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчид, бүсээр	18
Зураг 6. Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн ажлын байрны хэлбэр /сургуулийн төрлөөр/ ...	19
Зураг 7. Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн ААНБ-ын ажилтны тооны бүлгээр	19
Зураг 8. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн ажил олгогч байгууллагын хэлбэр, оноор	20
Зураг 9. Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа шалтгаан /сургуулийн төрлөөр /.....	21
Зураг 10. Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа төгсөгчид сургуулийн төрлөөр	21
Зураг 11. Ажлын байран дахь ур чадварын хомсдол, оноор.....	24
Зураг 12. Ажлын байранд дасан зохицоход тулгардаг бэрхшээл /сургуулийн төрлөөр/	25
Зураг 13. Ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлс.....	25
Зураг 14. Ажил үүрэг, эзэмшсэн мэргэжлийн нийцтэй байдал /сургуулийн төрөл, оноор/	25
Зураг 15. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид ажил мэргэжлийн ангиллаар	26
Зураг 16. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн цаашид тогтвортой ажиллах шалтгаан	27
Зураг 17. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн цаашид тогтвортой ажиллахгүй шалтгаан / сургуулийн төрлөөр /.....	27
Зураг 18. Ажлын байрны мэдээллийн эх сурвалж / сургуулийн төрлөөр/	28
Зураг 19. Давхар хөдөлмөр эрхэлж буй шалтгаан / сургуулийн төрлөөр/.....	29
Зураг 20. 2015 онд хөдөлмөр эрхлээгүй төгсөгчдийн 2016 оны хөдөлмөр эрхлэлтийн төлөв	30
Зураг 21. 2015, 2016 онуудад ажилгүй байгаа төгсөгчдийн ажилгүй байгаа болон эдийн засгийн идэвхигүй байдлын шалтгаан	31
Зураг 22. 2015 онд хөдөлмөр эрхэлж байсан, 2016 онд ажилгүй байгаа ажлаас гарсан төгсөгчдийн байгууллагаас хамаарсан шалтгаан / сургуулийн төрлөөр/	32
Зураг 23. Эдийн засгийн идэвхигүй байгаа төгсөгчдийн сүүлийн 30 хоногт ажил хайгаагүй шалтгаан.....	32
Зураг 24. Ажил хайх хэлбэр, оноор.....	33
Зураг 25. Ажил хайх явцад тулгардаг хүндрэл бэрхшээл / 2015, 2016 он /	34
Зураг 26. Эдийн идэвхигүй байгаа шалтгаан	34
Зураг 27. Эдийн засгийн идэвхигүй байгаа төгсөгчдийн ойрын нэг жилийн төлөвлөгөө	35

Зураг 28. Урт хугацааны мэргэжил эзэмшүүлэх сургалтын төрөл.....	36
Зураг 29. Богино хугацааны сургалтын төрөл.....	37
Зураг 30. Дахин суралцаж буй шалтгаан	37
Зураг 31. Суралцаж байгаа мэргэжил болон өмнөх мэргэжлийн нийцэл.....	38
Зураг 32. Төгсөгчдийн ойрын нэг жилийн төлөвлөгөө	38
Зураг 33. Суралцах төлөвлөгөөтэй байгаа төгсөгчид сургалтын төрлөөр.....	39

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА, АРГА ЗҮЙ

1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны зорилго нь дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн мэргэжил, ур чадварын хөгжил болон хөдөлмөр эрхлэлтийн байдал, ажлын байранд зуучлагдаж буй хэлбэр, хугацаа, ур чадварын нийцэл, түүнчлэн ажлын байранд тулгарч буй болон ажилгүй байгаа шалтгаан зэргийг илрүүлэн, салбарын бодлого боловсруулагчид, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын шийдвэр гаргагчид, судлаачдыг тоон мэдээллээр хангахад оршино.

СУДАЛГААНЫ ЗОРИЛТУУД:

Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тусгасан.

- Төгсөгчдийн боловсролын түвшин, гэр бүлийн ахуй амьдралын талаарх өөрчлөлтийг судлах,
- Төгсөгчдийн ажлын байрны хэлбэр, статус, ажил, амралтын цаг, хөдөлмөрийн хөлс зэрэг үзүүлэлтүүдийн өөрчлөлт, давхар ажил хийж буй төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн онцлог зэргийг тодорхойлох,
- Төгссөний дараах сургалтанд хамрагдсан байдлыг тодруулах /сургалтын төрөл, төлбөр гэх мэт/,
- 2015 онд ажилгүй байсан, одоо ажилгүй байгаа төгсөгчдийн ажилгүйдлийн шалтгааныг тодруулах,
- Ажил хайж байгаа төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн статус, тэдгээрийн шалтгаан, хэлбэр болон хичээл зүтгэлийг судлах,
- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх хэтийн төлөвлөгөө, зорилгыг тодруулах,
- Судалгааны үр дүнд тулгуурлан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, боловсролын болон хөдөлмөр эрхлэлтийн салбарын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмжийг боловсруулах.

1.2 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаагаар их, дээд сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, хөдөлгөөнийг судалдаг. Судалгааны хамрах хүрээ буюу эх олонлог нь Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг 2012-2013 оны хичээлийн жилд суралцаж төгссөн 60.6 мянган төгсөгч юм.

1.3 СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

Судалгааны түүврийн нэгж нь 2012-2013 оны хичээлийн жилд сургалтын байгууллагыг дүүргэж мэргэжил эзэмшсэн төгсөгч байна.

Түүврийн эх олонлог, хүрээ: Уг судалгаанд Монгол улсын их дээд сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийг хамруулах зорилт тавигдсан бөгөөд судалгааны түүврийн хүрээ 2012-2013 оны хичээлийн жилд төгсөгчдийн нийт тоогоор тодорхойлогдоно.

Хүснэгт 1. Эх олонлогийн ерөнхий мэдээлэл

Төгсөгчдийн тоо	2012/2013
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тоо	75
Их, дээд сургуулийн тоо	99
Дүн	174
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид	23 393
Их, дээд сургууль төгсөгчид	37 243
Дүн	60 636

Түүврийн хэмжээ: Түүврийн хэмжээ нь судалгааны онцлогоос хамааран харилцан адилгүй байдаг. Гол шаардлага нь эх олонлогоо төлөөлөх чадвартай байх явдал бөгөөд дараах хүчин зүйлийг анхаарч үзсэн. Үүнд:

- Цаг хугацааны боломж
- Судалгааны үр дүн нарийвчлалтай, бодитой байх шаардлага
- Байж болох алдааны түвшин

Түүвэр судалгааны хэмжээг тодорхойлоход дараах үндсэн томъёог ашигласан (1).

Түүврийн хэмжээг хүлээн зөвшөөрөх алдааны хязгаар буюу үр дүнгийн нарийвчлал болон үзэгдлийн тархалтын тохирох ач холбогдлын түвшинд нийцүүлэн тодорхойлсон.

Судалгаанд шаардлагатай түүврийн хэмжээг дараах томъёогоор тооцсон. Үүнд:

$$n = \frac{z^2 p(1-p)}{e^2} Deff \quad (1)$$

Эх олонлогийн хэмжээ мэдэгдэж байгаа учир дээрх томъёоны дагуу тооцсон түүврийн хэмжээг дараах томъёоны дагуу шинэчлэн тооцсон.

$$n^* = \frac{n}{1 + \frac{n}{N}} \quad (2)$$

n-түүврийн хэмжээ

Z- тодорхой хувийн ач холбогдолын түвшин дэх t статистикийн тархалтын утга

p- түүврийн хэмжээг тодорхойлоход ашиглах түлхүүр үзүүлэлтийн хувийн жин

e-судалгаанд дэвшүүлж байгаа хүлээн зөвшөөрөх алдааны хязгаар

N- өгөгдсөн түүврийн хүрэн дэх эх олонлогийн хэмжээ

Дээрх томъёоллын дагуу түүврийнхээ хэмжээг тодорхойлохын тулд дээрх өгөгдсөн хувьсагчдын утгыг тодорхойлсон.

Z- 95 хувийн ач холбогдлын түвшин дэх t статистикийн тархалтын утга 1,96

p- хэрвээ судалгааны түлхүүр үзүүлэлтийн мэдээлэл өгөгдөөгүй үед тус үзүүлэлтийн хувийн жинг **50** хувиар авдаг.

e- таамаглаж байгаа алдааны хязгаар буюу үр дүнгийн нарийвчлалын түвшинг практикт 5.0 хувийн харьцангуй болон абсолют алдаатай байхыг зөвшөөрөгдөхүйц хангалттай гэж үздэг. Бидний тохиолдолд (4.3%)

Deff- кластерийн нөлөө байгаа үед энэ утгыг өмнө үеийн утгаар эсвэл өмнө нь ямар нэгэн ижил төстэй судалгаа явагдаж байгаагүй тохиолдолд 2-той тэнцүү байна гэж таамагладаг. Бидний тохиолдолд 1-тэй тэнцүү байсан.

Хүснэгт 2. Түүврийн хэмжээг тодорхойлсон байдал

	Z ²	p	1-p	e(a)	e ² (a)	e(x)	n	N	n*
Түлхүүр үзүүлэлт = 0,5, Харьцангуй алдааны хязгаар = 0.043	3.84	0.50	0.50	0.022	0.00046	0.043	2068	60636	2000

Дээрх тооцооны хувьд түүврийн хэмжээ 2000 байх бөгөөд үүнийг ИДС болон МБСБ-д тодорхой зарчмын дагуу хуваарилах шаардлагатай болно. Бидний хувьд төгсөгчдийн тоонд пропорционалиар хуваарилсан бөгөөд хүснэгтэд үзүүлсний дагуу ИДС болон МБСБ төгсөгчдийг судалгаанд хамруулсан.

Хүснэгт 3. Түүврийн хэмжээг хуваарилсан байдал

Төрөл	Эх олонлог	Түүвэрлэгдэх хэмжээ	Таамаглаж буй алдааны хязгаар
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчид	23 393	768	0,07
Их, дээд сургууль төгсөгчид	37 243	1 232	0,055
Дүн	60 636	2 000	

Ийнхүү ИДС болон МБСБ төгсөгчдийн 2 бүлэгт түүврийн хэмжээг хуваарилсаны дараа, ИДС төгсөгчдөө мэргэжил, салбарынх чиглэлийн дагуу 22 дэд хэсэгт тэнцүү хуваарилсан болно. Харин МБСБ төгсөгчдийг бүхэлд нь нэг бүлэг гэж үзсэн. Сүүлийн шатанд 22 дэд хэсэг болон МБСБ төгсөгчдийн жагсаалтыг боловсруулж, бүлэг тус бүрээс харгалзах төгсөгчийн тооны дагуу энгийн санамсаргүй түүврийн аргаар сонголтыг хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 4. 2014-2016 онд судалгаанд хамрагдсан байдал

Төрөл	Эх олонлог	2014 он	2015 он	2016
Дүн	60 636	2 000	1719	1554

Жич: Анх 2014 онд судалгаанд хамрагдсан төгсөгчдийг хоёр жилийн хугацаанд мөшгөн судалсан болно. Түүвэрлэн авсан 2000 төгсөгчөө 2015, 2016 онуудад дахин судалгаанд хамруулсан бөгөөд 446 төгсөгч судалгаанд хамрагдахаас татгалзах, холбоо барих хэрэгслийн мэдээлэл өөрчлөгдөх, гадаад явах зэрэг шалтгааны улмаас түүврийн хэмжээ багассан.

1.4. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.4.1 Судалгааны асуулгын хуудас, мэдээлэл цуглуулалт

Судалгааны асуулга нь 6 бүлэг 104 асуулгаас бүрдэж байна. Судалгааны асуулгыг судалгааны зорилго, зорилт хамрах хүрээг харгалзан үзэж бусад ижил төсөөтэй судалгааны асуулгыг судалж боловсруулсан. Үүнд:

- 1-р бүлэгт Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл /хүн ам зүйн мэдээлэл/
- 2-р бүлэгт Одоогийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээлэл
- 3-р бүлэгт Сүүлийн нэг жилийн ажлын туршлагын талаарх мэдээлэл
- 4-р бүлэг Ажил хайж буй эсэхтэй холбоотой мэдээлэл
- 5-р бүлэгт Сүүлийн нэг жилийн сургалтын мэдээлэл
- 6-р бүлэгт Цаашдын төлөвлөгөөний талаарх мэдээлэл

Судалгааны мэдээлэл цуглуулах, шивэх үйл ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу “Эм Си Ди Эс” ХХК гүйцэтгэсэн.

1.4.2 Судалгааны мэдээлэл боловсруулалт

Түүвэрлэлтийн бус алдаа буюу шивэлтийн үеийн алдааг багасгахад анхаарч ажиллаж, шалгалтыг тогтмол хийсэн. Судалгааны CSPro 5.0 программаар мэдээлэл оруулах (Data entry tools) болон мэдээллийг шалгах, засварлах ажлыг гүйцэтгэсэн.

Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх, нэгдсэн хүснэгт, үр дүн гаргахад SPSS болон MS Excel программ хангамжийг ашигласан.

1.5. СУДАЛГААНЫ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

- Судалгаанд төгсөгчдийн мэргэжлийн чиглэлд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн тогтоох тухай” 235 дугаар тушаалаар батлагдан мөрдөж буй дээд боловсролын болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн ерөнхий чиглэлийг баримталсан. Их, дээд сургууль төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийг 22 мэргэжлийн чиглэл, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийг 11 мэргэжлийн чиглэлд нэгтгэн авч үзсэн.
- Судалгааны ажил мэргэжлийн мэдээлэлд “Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт 2008”, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын мэдээлэлд Сангийн сайдын 2011 оны 103 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ыг тус тус мөрдлөг болгосон.
- Тайланд дурдагдаж буй нэр томъёо, тооцооллыг дараах байдлаар ойлгоно.
 - **Төгсөгч:** 2012-2013 онд их, дээд сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг сургалтын багц цагийг ханган, төгсөлтийн шалгалтанд тэнцэн, бакалаврын диплом, мэргэжлийн боловсролын болон мэргэжлийн үнэмлэх авсан суралцагч
 - **Ажлын туршлагатай төгсөгч:** Сургууль төгссөн сараас судалгааны мэдээлэл цуглуулах хүртэл нийт 17 сар өнгөрсөн ба энэ хугацаанд 1 ба түүнээс дээш тооны ажил хийсэн төгсөгч
 - **Ажиллагч:** Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон төгсөгч
 - **Ажил хайгч:** Ажилгүй учраас ажил хийхээр ажил хайж байгаа, ажилтай боловч ажлын нөхцлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа төгсөгчдийн нийт дүнгээр тооцсон.
 - ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулинд “Ажил хайгч” гэж ажилгүй иргэн, ажилтай боловч ажлын нөхцлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж, хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн болон хандсан иргэнийг хэлнэ гэж томъёолсон.
 - **Суралцагч:** Судалгааны мэдээлэл цуглуулах хугацаанд дээд боловсролын болон мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын байгууллагад дахин суралцаж байгаа төгсөгч

- **Хөдөлмөр эрхлэлтийн хувь:** Нийт төгсөгчдөд ажил хийж буй төгсөгчдийн эзлэх хувийн жингээр илэрхийлэгдэнэ.

$$\text{Хөдөлмөр эрхлэлтийн хувь} = \frac{\text{Ажил хийж буй төгсөгч}}{\text{Нийт төгсөгч}} \times 100$$

- **Цалинтай ажилтан:** Цалин хөлстэй ажилтан буюу хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан, эсхүл аман болон хоёр талын тохиролцоогоор ажилладаг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг, ажил олгогчдод ажил, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг иргэнийг хамруулна.
- **Байнгын ажилтан:** Байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон Төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг хэлнэ.
- **Ажил үүргийн шаардлага, эзэмшсэн ур чадвартай нийцэх түвшин:** Ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүргийн шаардлагын түвшин эзэмшсэн ур чадвартай “нийцтэй” гэж үзсэн үнэлгээний утга
 - ✓ Нийцлийн түвшинг “ажил үүргийн шаардлагын түвшин хэт доогуур – 1”, “ажил үүргийн шаардлагын түвшин доогуур – 2”, “ажил үүргийн шаардлагын түвшин тохиромжтой – 3”, “ажил үүргийн шаардлагын түвшин өндөр - 4”, “ажил үүргийн шаардлагын түвшин хэт өндөр - 5” гэсэн таван түвшингээр хэмжсэн.
- **Ажил үүргийн шаардлага, эзэмшсэн боловсролтой нийцэх түвшин:** Ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүргийн шаардлагын түвшин эзэмшсэн боловсролтой “нийцтэй” гэж үзсэн үнэлгээний утга
 - ✓ Нийцлийн түвшинг “ажил үүргийн шаардлагын түвшин хэт доогуур – 1”, “ажил үүргийн шаардлагын түвшин доогуур – 2”, “ажил үүргийн шаардлагын түвшин тохиромжтой – 3”, “ажил үүргийн шаардлагын түвшин өндөр - 4”, “ажил үүргийн шаардлагын түвшин хэт өндөр - 5” гэсэн таван түвшингээр хэмжсэн.
- **Мэргэжил, ажил үүргийн нийцлийн түвшин:** Ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэг буюу ажил мэргэжил нь эзэмшсэн мэргэжилтэй “тохирдог” гэж үзсэн үнэлгээний утга
 - ✓ Ажлын байрны ажил үүргийг YAMAT-08 дах ажил мэргэжлийн дэд бүлгийн нэрд хөрвүүлэн судалсан ба нийцлийн түвшинг “ажил үүрэг эзэмшсэн мэргэжилтэй огт тохиромжгүй - 1”, “ажил үүрэг эзэмшсэн мэргэжилтэй тийм ч тохиромжтой биш - 2”, “ажил үүрэг эзэмшсэн мэргэжилтэй хэвийн нийцдэг – 3”, “ажил үүрэг эзэмшсэн мэргэжилтэй тохирдог – 4”, “ажил үүрэг эзэмшсэн мэргэжилтэй маш тохиромжтой - 5” гэсэн таван түвшингээр хэмжсэн.
- **251-ээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллагад ажилладаг ажилтны хувь:** Нийт ажлын туршлагатай төгсөгчдөөс 251-ээс дээш тооны ажилтантай том аж ахуйн нэгж байгууллагад ажилладаг төгсөгчдийн эзлэх хувийн жингээр илэрхийлэгдэнэ.
 - ✓ Судалгаанд аж ахуйн нэгж байгууллагын ажилтны тоог “10 хүртэлх ажилтантай”, “11-50 ажилтантай”, “51-100 ажилтантай”, “101-250 ажилтантай”, “251-ээс дээш ажилтантай” гэсэн интервалтайгаар авч үзсэн.
- **Сарын дундаж цалин, орлого:** Цалин хөлстэй ажилтны хувьд цалингаар, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил олгогчийн хувьд орлогоор илэрхийлэгдэнэ. Нийт төгсөгчдийн сарын цалин, орлогын арифметик дунджаар тооцсон утга болно.

- **251-ээс тооны ажилтантай аж ахуйн нэгж байгууллагын ажилтны дундаж цалин:** 251-ээс дээш тооны ажилтантай аж ахуйн нэгж байгууллагад ажилладаг нийт төгсөгчдийн сарын дундаж цалингийн арифметик дунджаар тооцсон утга болно.
- **7 хоногийн ажлын дундаж цаг:** Ажил хийж буй төгсөгчдийн 7 хоногийн ажлын цагийн арифметик дунджаар тооцсон утга

БҮЛЭГ 2. ТӨГСӨГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1 ТӨГСӨГЧИЙН ХҮН АМ ЗҮЙН ТӨЛӨВ

Судалгаанд 2012-2013 оны хичээлийн жилд мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагыг мэргэжлийн анхан шатны болон түүнээс дээш түвшний боловсрол эзэмшин төгссөн 60.6 мянган төгсөгчийг төлөөлүүлэн 2000 төгсөгчийг хамруулсан.


Нийт төгсөгчдийн 61.4 хувь буюу 37.2 мянга нь их, дээд сургууль, коллеж, 38.6 хувь буюу тэнцэх 23.4 мянга нь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгсөгчид байгаа бөгөөд хүйсийн хувьд 56.0 хувь нь эмэгтэйчүүд, 44.0 хувь эрэгтэйчүүд байжээ².

Судалгаанд хамрагдагсдын дундаж нас 26, дээд сургууль төгсөгчдийн хувьд 27 байна. Төгсөгчдийг насны бүлгээр үзэхэд 23-27 насныхан бусад насны бүлэгт харьцуулахад илүү өндөр хувийн жинтэй буюу нийт төгсөгчдийн 64.6 хувь нь 23-27 насныхан, 18-22 насныхан 17.4 хувь, 28-32 насныхан 11.7 хувь байгаа бол, 33-аас дээш насныхан бусад насныхнаас илүү цөөн 6.2 хувь буюу 3.7 мянга байна.

Төгсөгчдийн насны бүтцийг сургалтын байгууллагын төрлөөр үзвэл харилцан адилгүй дүр зураг ажиглагдаж байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын мэргэжлийн боловсролын сургалтанд суурь/бүрэн бус дунд/ боловсрол эзэмшсэн хүүхэд залуус элсэн суралцдаг, нөгөө талаас сургалтын нийт хугацаа богино байдаг зэрэг хүчин зүйлтэй шууд хамааралтайгаар дундаж нас 24, их дээд сургууль төгсөгчдийн дундаж нас 27 байна.

Зураг 1. Төгсөгчдийн хүн ам зүйн үзүүлэлт

Хэмжих нэгж: тоо




Төгсөгчдийн гэрлэлтийн байдлаар тодруулбал нийт төгсөгчдийн 45.7 хувь буюу 27.6 мянга нь гэрлээгүй, 35.5 хувь буюу 21.5 мянга нь гэр бүлээ батлуулсан, 18.9 хувь буюу 11.4 мянга нь гэр бүлээ батлуулаагүй байна.

² 2012-2013 оны хичээлийн жилд МСҮТ-ийг 23,3 мянган төгсөгч /Эх сурвалж: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Статистикийн үзүүлэлт 2013/, их, дээд сургууль, коллежийг 37,2 мянган төгсөгч /Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Статистикийн эмхэтгэл/ тус тус төгссөн мэдээлэл байдаг. Тус судалгаанд 2013-2014 оны хичээлийн жилийн өвлийн ээлжинд дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийг хамруулаагүй.

Зураг 2. Өрхийн сарын дундаж орлого

Хэмжих нэгж: хувиар



Өрхийн сарын дундаж орлогын хэмжээг 250.0 мянган төгрөг хүртэлх, 1.5 сая төгрөгөөс дээш гэсэн байдлаар бүлэглэн авч үзсэн. Нийт төгсөгчдийн дунд өрхийн сарын дундаж орлого нь 501.0-750.0 мянган төгрөг байдаг бүлэг хамгийн их буюу 27.2 хувь, хамгийн цөөн нь 1.5 сая төгрөгөөс дээш төгрөгийн сарын орлоготой нь 6.4 хувь байлаа.

2.2 ТӨГСӨГЧДИЙН ЭЗЭМШСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙДАЛ

Төгсөгчдийн мэргэжлийн тархалтыг их дээд сургууль, коллеж болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв тус бүрээр авч үзвэл.

Хүснэгт 5. ИДС төгсөгчид /мэргэжлийн чиглэлээр/

Хэмжих нэгж: тоо


Мэргэжлийн индекс	Салбар, мэргэжлийн чиглэл	Дипломын (дээд) боловсрол	Бакалаврын дээд боловсрол	Магистр ба түүнээс дээш	Нийт төгсөгчид
	Бүгд	1 181	32 234	3 828	37 243
14	Багш, боловсрол судлал	15	5 548	570	6 133
21	Урлаг	6	617	68	691
22	Хүмүүнлэгийн ухаан	2	2 016	272	2 290
31	Нийгэм, эдийн засаг	2	2 222	208	2 432
32	Мэдээлэл, сэтгүүл зүй	-	519	36	555
34	Бизнес удирдлага	19	7 964	1 091	9 074
38	Хууль, эрх зүй	-	1 674	551	2 225
42	Биологи	1	181	70	252
44	Физик, хими, биологи, газар зүй	5	563	149	717
46	Математик, статистик	-	97	27	124
48	Компьютер	8	1 054	25	1 087
52	Бүх төрлийн инженер	40	2 003	228	2 271
54	Үйлдвэрлэлийн технологи	45	1 473	106	1 624
58	Барилга, архитектур	33	769	44	846
62	ХАА, ОАА, ЗАА	1	650	62	713
64	Мал эмнэлэг	-	153	24	177
72	Анагаах ухаан	989	2 333	148	3 470
76	Нийгмийн халамж, хангамж	-	422	4	426

81	Биеийн тамир, спорт зарим төрлийн үйлчилгээ	-	611	36	647
84	Тээвэр	13	144	-	157
85	Байгаль хамгаалал	2	418	59	479
86	Цэрэг цагдаа аюулгүй байдал	-	803	50	853

Их дээд сургууль төгсөгчдийн 56.2 хувь буюу 20.9 мянга нь төрийн өмчийн сургууль төгсөгчид, 43.8 хувь буюу 16.3 мянга нь хувийн өмчийн сургуульд суралцаж, төгссөн байна. Хувийн их дээд сургууль, коллежийн хувьд бизнес удирдлага мэргэжлийн чиглэлээр төгсөгчид их байна. Тухайн жилийн ИДС төгсөгчдийн мэргэжлийн хувьд 24.4 хувийг бизнес, удирдлага, 16.5 хувийг багш боловсрол судлалын мэргэжил эзэмшсэн төгсөгчид эзэлж байгаа нь хамгийн өндөр хувьтай байгаа бол нийгэм-эдийн засаг, хүмүүнлэгийн ухаан, хууль эрхзүй, анагаах ухаан, бүх төрлийн инженерүүд гэсэн чиглэлээр төгсөгчид бусад мэргэжилтэй харьцуулахад илүү байна.

Зураг 3. МБСБ төгсөгчид /мэргэжил, сургуулийн өмчийн хэлбэрээр/

Хэмжих нэгж: тоо



Улсын хэмжээнд 2012-2013 оны хичээлийн жилд 78 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулсны 64.1 хувь буюу 50 нь төрийн өмчийн сургууль бөгөөд төгсөгчдийн 80.4 хувь нь эдгээр сургуулийг төгссөн байна. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн төгсөгчдийн дунд барилга, автозам, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын мэргэжилтнүүд хамгийн олон байсны зэрэгцээ аж үйлдвэр, геологи, уул уурхай, захиргааны үйлчилгээний салбарын мэргэжилтэй төгсөгчид бусад мэргэжлийн чиглэлүүдтэй харьцуулахад олноор төгсчээ.


БҮЛЭГ 3. ТӨГСӨГЧИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

3.1 Хөдөлмөр эрхэлдэг төгсөгчдийн ажлын байрны төлөв байдал, онцлог, шалтгаан

Судалгааны тайлангийн энэ хэсэгт төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, онцлогийг харуулав. 2016 онд судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 61.6 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа нь өмнөх оноос 5.1 пунктээр буурсан байна. Нийт эрэгтэй төгсөгчдийн 69.0 хувь нь, эмэгтэй төгсөгчдийн 56.6 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн 45.2 хувь нь эрэгтэйчүүд, 54.8 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 3. 2015 – 2016 онд гарсан хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт


Хэмжих нэгж: хувиар



2015 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 52.3 хувь нь 2016 онд хөдөлмөр эрхэлж байгаа бол 12.4 хувь нь ажилгүй, 0.9 хувь нь сурч байна. 2015 онд ажилгүй байсан төгсөгчдийн 5.4 хувь нь 2016 онд ажил хийж байгаа, 17.6 хувь нь ажилгүй, үлдсэн 0.9 хувь нь сурч байна. Өмнөх онд сурч байсан төгсөгчдийн 5.0 хувь нь 2016 онд ч сурч байна.


Зураг 4. Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчид, бүсээр

Хэмжих нэгж: хувиар




Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийг байршлаар нь харвал 10 төгсөгч тутмын 6 нь Улаанбаатар хотод хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчид бүсүүдээр ихээхэн ялгаатай байна.

Зураг 5. Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн ажлын байрны хэлбэр /сургуулийн төрлөөр/



Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 84.0 хувь нь байнгын, 10.5 хувь нь улирлын чанартай, 5.5 хувь нь түр болон цагийн ажил эрхэлж байна. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийг сургуулийн төрлөөр нь харвал их, дээд сургууль төгсөгчдийн 10 төгсөгч тутмын 9 нь, МБСБ төгсөгчдийн 10 төгсөгч тутмын 7 нь байнгын ажлын байранд ажиллаж байна.

Зураг 6. Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчид, ААНБ-ын ажилтны тооны бүлгээр



Монгол улсын хэмжээнд 2016 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 69.5 мянган аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 83.6 хувь нь 1-9 хүртэлх ажилтантай, 12.8 хувь нь 10-49 ажилтантай, үлдсэн 3.5 хувь нь 50-аас дээш тооны ажилтантай гэсэн статистик мэдээ байна³. Төгсөгчдийн 49.4 хувь нь 50 хүртэлх, 22.0 хувь нь 251-с дээш ажилтантай ААНБ-д ажиллаж байна. Хамгийн олноор ажиллаж буй 11-50 ажилтантай байгууллагад ИДС төгсөгчдийн 27.8 хувь, МБСБ төгсөгчдийн 31.5 хувь нь ажиллаж байна.

³ ҮСХ, www.1212.mn, Статистик мэдээллийн сан 2016, 3-р улирал

Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн 87.7 хувь нь нийгмийн даатгал төлдөг. Энэ дүн их дээд сургууль төгсөгчдийн хувьд 93.2, МБСБ төгсөгчдийн хувьд 75.1 хувь байгаа ба ИДС төгсөгчид МБСБ төгсөгчдөөс илүү нийгмийн даатгалын шимтгэл төлж байна. Ажиллаж буй төгсөгчдөөс эрүүл мэндийн даатгал төлдөг эсэхийг тодруулахад нийт төгсөгчдийн 92.5 хувь нь төлдөг ажээ. Харин хувь хүний орлогын албан татвар төлөлтийн хувьд 83.2 хувь нь ХХОАТ төлдөг, 16.8 хувь нь төлдөггүй байна. Сургуулийн төрлөөр нь харвал ИДС төгсөгчдийн 88.9 хувь нь, МБСБ төгсөгчдийн 70.4 хувь нь ХХОАТ төлдөг байна.

Хүснэгт 6. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн статус, оноор


Хэмжих нэгж: хувиар

Сургуулийн төрөл	Он	Цалин хөлстэй ажилтан	Цалин хөлсгүй ажилтан		
			Ажил олгогч	Хувиараа	Өрхийн бизнес
Нийт	2014 он	95,1	0,6	4,1	0,2
	2015 он	95,4	0,6	3,7	0,3
	2016 он	96,5	0,2	2,4	0,9

2016 онд ажил хийж байгаа төгсөгчдийн 96.5 хувь нь цалин хөлстэй ажилтны статусаар хөдөлмөр эрхлэгч бол, тэдний 86.4 хувь нь байнгын ажилтан, 3.7 хувь нь түр ажилтан, 9.9 хувь улирлын чанартай ажил хийдэг байна. Цалин хөлстэй ажилтан өмнөх оноос 1.1 пунктээр өссөн дүнтэй гарчээ.

Зураг 7. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн ажил олгогч байгууллагын хэлбэр, оноор

Хэмжих нэгж: хувиар




Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийг ажиллаж буй аж ахуйн нэгж байгууллагын хэлбэрээр харвал төгсөгчдийн 70 гаруй хувь нь дотоодын хөрөнгө оруулалттай компани болон төрийн байгууллагад ажиллаж байна. Сургуулийн төрлөөр нь харвал ИДС төгсөгчдийн 34.6 хувь нь МБСБ төгсөгчдийн 53.0 хувь нь дотоодын хөрөнгө оруулалттай компанид ажиллаж байна.

ИДС төгсөгчдийн 40.2 хувь нь, МБСБ төгсөгчдийн 18.6 хувь нь төрийн байгууллагад ажиллаж байгаа бол хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчид өмнөх онтой харьцуулахад буурсан байна.

Зураг 8. Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа шалтгаан /сургуулийн төрлөөр /


Хэмжих нэгж: хувиар



Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 6.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж байна. Тэдгээр төгсөгчдийн 14.0 хувь нь мэргэжлийн ажил олдохгүй, 12.1 хувь нь орлого амьжиргаанд хүрэлцэхгүй байсан, 9.4 хувь нь гэр бүлийн бизнес, аж ахуй эрхэлдэг зэрэг шалтгааны улмаас хувиараа хөдөлмөр эрхлэх болсон гэсэн. Сургуулийн төрлөөр нь тодруулбал ИДС төгсөгчдийн 27.4 хувь нь цалин хөлстэй ажилтнаас илүү орлого олдог, 28.0 хувь нь амжилт гаргах хөгжих боломжтой гэсэн бол МБСБ төгсөгчдийн хувьд 20.1 хувь нь мэргэжлийн ажил олдохгүй, 18.8 хувь нь цагт баригдаж ажиллах сонирхолгүй шалтгааны улмаас хувиараа хөдөлмөр эрхэлдэг гэсэн.

Зураг 9. Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа төгсөгчид /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: хувиар



ИДС-ийн төгсөгчдийн 86.8 хувь нь, харин МБСБ-ийн төгсөгчдийн 69.3 хувь нь л хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. Өөрөөр хэлбэл хөдөлмөр эрхэлж байгаа ч хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй тохиолдол МБСБ-ын төгсөгчдийн дунд нилээд өндөр, бараг гурван хүн тутмын нэг байгааг анхаарах шаардлагатай юм. Асуудлын тодруулан, ажлын байрны хэлбэрээр нь харвал 68.3 хувь нь байнгын, 31.7 хувь нь улирлын болон түр ажлын байранд ажиллаж байна. Хөдөлмөрийн гэрээгүй ажиллаж байгаа төгсөгчдийн сарын дундаж цалин 579.2 мянган төгрөг байна.

Цалин хөлстэй ажилтны хувьд 81.4 хувь нь хөдөлмөрийн гэрээтэй, 18.6 хувь нь хөдөлмөрийн гэрээгүй ажиллаж байна. Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа төгсөгчдийн 50.5 хувь нь хугацаатай, 49.5 хувь нь хугацаагүй гэрээ байгуулан ажиллаж байна.

Хүснэгт 7. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 7 хоногийн ажлын өдөр, цаг /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: хувиар

Сургуулийн төрөл	7 хоногийн дундаж ажлын өдөр	7 хоногийн дундаж ажлын цаг	7 хоногийн нэмэлт ажлын цаг
ИДС	5,2	45,0	11,3
МБСБ	5,4	52,0	12,1
Дундаж	5,3	48,0	11,5

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 7 хоногийн ажлын дундаж өдөр нь энгийн ажлын цагийн горимын дагуу бөгөөд 12.1 хувь нь 7 хоногийн 7 өдөр ажиллаж байна. Үүнийг сургуулийн төрлөөр нь тодруулбал, ИДС төгсөгчдийн 7.8 хувь нь, МБСБ төгсөгчдийн 21.8 хувь нь 7 хоногийн 7 өдөр ажиллаж байна.

Хүснэгт 8. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн сарын дундаж цалингийн хэмжээ /он, сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: хувиар

Сургуулийн төрөл	Сарын дундаж цалин орлого /мян төгрөг/		
	2014 он	2015 он	2016 он
ИДС	642464	678876	672 374
МБСБ	569872	654026	609 589
Дундаж	606168	666451	640 981

Сарын дундаж ажлын өдөр, амралтын өдрүүдэд нэг жилийн хугацаанд өөрчлөлт харагдсангүй. Төгсөгчдийн сарын дундаж цалин, хөлс орлогын хэмжээ 1 жилийн өмнөхөөс 25.4 мянган төгрөгөөр буурсан бөгөөд МБСБ төгсөгчдийн цалин өмнөх оноос 6.7 хувиар буурсан байна.

2016 онд төгсөгчдийн сарын дундаж цалингийн хэмжээ нь 640.2 мянган төгрөг байгаа ба Үндэсний статистикийн хорооны 2016 оны 3-р улирлын мэдээгээр 884.3⁴ мянган төгрөг байгаа нь төгсөгчдийн дундаж цалин, улсын дундаж цалинтай харьцуулахад бага байна.

Хүснэгт 9. Боловсролын түвшин, ажил үүргийн нийцтэй байдал, оноор

Хэмжих нэгж: хувиар

Он	Хэт доогуур	Доогуур	Тохиромжтой	Өндөр	Хэт өндөр
2014 он	2,7	12,6	75,9	7,0	1,8
2015 он	2,2	12,1	68,6	14,2	2,8
2016 он	1,8	15,1	71,6	10,7	0,8

Сүүлийн гурван жилийн судалгааны үр дүнгээс ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүргийн шаардлага, боловсролын түвшингийн тохиромжтой байдлыг харахад 70 гаруй хувь нь нийцтэй байдаг гэж хариулсан байна. Үлдсэн 30 хувьд нь боловсролын түвшнээс хамаарсан ажил үүргийн үл нийцэл байгаа гэжээ.

Хүснэгт 10. Ажил үүргийн шаардлага, ур чадварын нийцтэй байдал /Он, сургуулийн төрөл/

Хэмжих нэгж: хувиар

Он	Хэт доогуур	Доогуур	Тохиромжтой	Өндөр	Хэт өндөр
2014 он	2,4	11,6	75,9	9,6	0,5
2015 он	2,1	9,6	70,0	16,4	1,8
2016 он	1,2	11,5	75,1	11,3	1,0

Төгсөгчдийн 70 гаруй хувь нь гүйцэтгэж буй ажил үүргийн шаардлагын түвшин эзэмшсэн ур чадвартай нийцсэн байна. Сургуулийн төрлөөр харвал МБСБ төгсөгчдийн 72.0 хувьд, ИДС төгсөгчдийн 76.4 хувьд эзэмшсэн ур чадвар нь ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүргийн шаардлагад нь нийцдэг гэжээ. Төгсөгчдийн 10 гаруй хувь нь эзэмшсэн ур чадвараас ахадсан ажил үүргийн шаардлага бүхий ажлын байранд ажиллаж байна.

⁴ ҮСХ МУ-ын нийгэм, эдийн засгийн байдал I-XI сар, аж ахуй нэгж байгууллагын ажиллагчдын нийт цалингийн дундаж 884.3 мянган төгрөг

Зураг 10. Ажлын байран дах ур чадварын хомсдол, оноор

Хэмжих нэгж: хувиар




2014-2016 оны судалгааны үр дүнгээс харахад гадаад хэлний мэдлэг нь хамгийн их тулгарч буй ур чадварын хомсдолын нэг бөгөөд түүний хэрэгцээ шаардлага жил ирэх тутам нэмэгддэг байна. Түүнчлэн төгсөгчдөд тулгарч буй ур чадварын хомсдолд мэргэжлийн ур чадвар, багаар ажиллах чадвар зэрэг нь нилээдгүй хувийг эзэлсээр байна. Харин шинжлэх ухаан технологийн мэдлэг, мэдээллийн технологийг ашиглах, эзэмших зэрэг ур чадварууд нь ажлын байранд гарсан эхний жил тодорхой хувийг эзэлдэг ч, хугацаа өнгөрөх тусам дутагдах ур чадварт орох хувь нь багасч байна.

Цаашид төгсөгчдөд дутагдалтай байгаа ур чадварыг эзэмшүүлэх чиглэлийг баримтлах, сургалтын хөтөлбөрт тусгаж өгөх, хэвшил болгон хэрэглэж сурахад нь анхаарч хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байгаа ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх хэрэгтэй юм.

Зураг 11. Ажлын байранд дасан зохицоход тулгардаг бэрхшээл /сургуулийн төрлөөр/


Хэмжих нэгж: хувиар



Төгсөгчдийн ажлын байранд дасан зохицоход хамгийн ихээр тулгардаг бэрхшээл нь хамт ажиллагсад, удирдлагын харилцаа, ажлын хэв маягт дасах, ажлын туршлага дутах, ажлын орчин нөхцөл байдал, норм, төлөвлөгөө биелүүлэх явдал гэж судалгаанд оролцогчид үзжээ. ИДС төгсөгчдийн 22.4 хувь нь хамт ажиллагсад, удирдлагын харилцаа, МБСБ төгсөгчдийн 17.8 хувь нь ажлын хэв маягт дасах байдал нь ажлын байранд дасан зохицоход хамгийн их тулгардаг бэрхшээл гэж үзсэн байна.

Зураг 12. Ажилд ороход нөлөөлсөн хүчин зүйлс


Хэмжих нэгж: хувиар



Гурван жилийн судалгааны дүнгээр ажилд ороход хамгийн ихээр нөлөөлдөг хүчин зүйл нь эзэмшсэн мэргэжил, ярилцлагын ур чадвар, хувийн зан чанар, төгссөн сургууль, сурлагын дүн, оноо гэсэн байна.

Зураг 13. Ажил үүрэг, эзэмшсэн мэргэжлийн нийцтэй байдал /сургуулийн төрөл, оноор/


Хэмжих нэгж: хувиар



Төгсөгчдийн хувьд 10 хүн тутмын 6 нь эзэмшсэн мэргэжлээрээ ажилладаг байна. Мэргэжлээрээ ажиллаж байгаа чиглэлүүдийн хувьд ИДС төгсөгчдийн хувьд сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгүүл ба мэдээлэл, биологи, мал эмнэлэг, анагаах ухаан, цагдаа аюулгүй байдлын мэргэжлүүд бол МБСБ төгсөгчдийн хувьд захиргаа үйлчилгээний ажилтан, тээвэр зэрэг чиглэлүүд байна. Харин мэргэжлээрээ төдийлөн ажиллаж чадахгүй байгаа мэргэжлийн чиглэлүүдэд ИДС төгсөгчдийн хувьд нийгмийн халамж, хамгаалал, ХАА, ОАА, ЗАА, хүмүүнлэгийн ухаан, бизнес ба мэдээлэл, МБСБ төгсөгчдийн хувьд ОАА мод боловсруулах салбар, ХАА үйлдвэрлэл, мэдээллийн технологи зэрэг чиглэлүүд байна. Цаашид мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн шалтгааныг нь тодруулан, ХЗЗ-ын тухайн мэргэжлийн ажлын байрны хомсдол уу, эсхүл төгсөгчийн ур чадварын дутагдал эсэхийг судлах шаардлагатай юм.

Зураг 14. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид /ажил, мэргэжлийн ангиллаар/

Хэмжих нэгж: хувиар




Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн бараг 50 хувь нь мэргэжилтэн бүлэгт хамаарагдах ажлын байранд ажиллаж байна. ИДС төгсөгчдийн 59.6 хувь нь мэргэжилтэн, 10.1 хувь нь худалдаа үйлчилгээний ажилтан бүлэгт хамаарах ажлын байранд ажиллаж байгаа бол, МБСБ төгсөгчдийн 24.9 хувь нь мэргэжилтэн, 24.0 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 21.9 хувь нь худалдаа үйлчилгээний ажилтан бүлэгт хамаарах ажлын байруудад ажиллаж байна.

Төгсөгчдөөс ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллагыг эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 21 салбараар нь тодруулбал 11.5 хувь нь худалдааны, 12.3 хувь нь боловсролын, 9.6 хувь нь эрүүл мэндийн, 9.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 9.1 хувь нь барилгын салбарт тус тус ажиллаж байна.


Төгсөгчдийн мэргэжлийн чиглэл, ажилладаг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын тархалтыг харьцуулсан дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1-ээс харах боломжтой.

Зураг 15. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн цаашид тогтвортой ажиллах шалтгаан



Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн тогтвортой ажиллах эсэх талаар тодруулахад 81.6 хувь нь тогтвортой ажиллана, 18.4 хувь нь ажлын байранд үлдэх сонирхолгүй байгаагаа илэрхийлсэн. Ажлын байрандаа үлдэх сонирхолгүй байгаа төгсөгчдийн шалтгааныг тодруулахад МБСБ төгсөгчдийн хувьд түр ажлын байр, сурах хүсэлтэй, мэргэжлээрээ ажиллах сонирхолтой гэсэн бол, ИДС төгсөгчдийн хувьд илүү хөгжих боломжтой, нөхцөл сайтай ажил хийх, түр ажиллаж байгаа, мэргэжил мэдлэг нь ур чадварт тохирдоггүй зэрэг шалтгаануудыг дурдсан байна.


Зураг 16. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн цаашид тогтвортой ажиллахгүй шалтгаан /сургуулийн төрлөөр/



Судалгаанд оролцогчдын дийлэнх нь тогтвортой ажиллана гэсэн бол 18.4 хувь нь ажлын байранд үлдэх сонирхолгүй байгаа гэжээ. Сургуулийн төрлөөр нь харвал ИДС төгсөгчдийн 17.1 хувь нь, МБСБ төгсөгчдийн 21.3 хувь нь одоогийн ажлын байрандаа цаашид тогтвортой ажиллахгүй байх төлөвтэй байна.

МБСБ төгсөгчдийн хувьд түр ажлын байр, сурах хүсэлтэй, мэргэжлээрээ ажиллах, ИДС төгсөгчдийн хувьд илүү хөгжих боломжтой, нөхцөл сайтай ажил хийх, түр ажиллаж байгаа, мэргэжил мэдлэг, ур чадварт тохирдоггүй болон бусад шалтгааны улмаас цаашид ажлын байраа солих сонирхолтой байгаагаа илэрхийлсэн байна.

Зураг 17. Ажлын байрны мэдээллийн эх сурвалж / сургуулийн төрлөөр/



Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдөөс ажлын байрны мэдээллийн эх сурвалжийг тодруулахад нийт төгсөгчдийн 22.7 хувь нь эцэг эх, хамаатан садан, 27.1 хувь нь найзууд, хамт суралцагсад, 21.6 хувь нь сонин ТВ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернет ажлын зараас авсан гэсэн.

Сургуулийн төрлөөр харвал МБСБ төгсөгчдийн 30.8 хувь нь эцэг эх, хамаатан саднаас, 28.2 хувь нь найз, нөхөд хамт суралцагсад, ИДС төгсөгчдийн 26.7 хувь нь найз, хамт суралцагсад, 19.4 хувь нь эцэг эх хамаатан саднаас ажлын байрны мэдээллийг түлхүү авдаг байна. Өөрөөр хэлбэл ажлын байрны мэдээллийг хувийн харилцаагаар дамжуулан авсан нь нилээд түгээмэл байна.

Давхар хөдөлмөр эрхлэлт

Энэ дэд бүлэгт одоо хийж байгаа ажлаасаа гадна 1 ба түүнээс дээш ажил давхар хийж байгаа төгсөгчдийн талаар судаллаа. Үүнд хийж буй давхар ажлын цаг, давхар ажил хийж буй шалтгаан, ажлын байрны хэлбэр зэрэг үзүүлэлтүүдийг тусгасан.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 4.9 хувь нь давхар ажил эрхэлдэг бөгөөд тэдний 69.5 хувь нь ИДС төгсөгч, үлдсэн 30.5 хувь нь МБСБ төгсөгч байна.

Давхар хөдөлмөр эрхэлж байгаа хугацааг асуухад нийт давхар ажил хийж байгаа төгсөгчид дунджаар 21 сар, тэр дундаа эмэгтэй төгсөгчдийн давхар ажил хийж байгаа хугацаа 26 сар буюу илүү урт, эрэгтэй төгсөгчдийнх 19 сар байна. Харин сургуулийн төрлөөр давхар ажил хийж байгаа хугацааг харвал ИДС төгсөгч 23 сар, МБСБ төгсөгч 17 сар байна.

Одоогийн хийж байгаа үндсэн ажил нь давхар ажилтай төсөөтэй эсэхийг тодруулахад давхар ажил хийж байгаа төгсөгчдийн 17.5 хувь нь ижил, 10.7 хувь нь төстэй, 71.8 хувь нь өөр гэж хариулсан. Сургуулийн төрлөөр харвал ИДС төгсөгчийн 20.2 хувь нь ижил, 13.6 хувь нь төстэй, 66.2 хувь нь өөр гэж хариулсан байхад МБСБ төгсөгчид 7.4 хувь нь адилхан, 92.6 хувь нь өөр ажил эрхэлдэг байна.

Хүснэгт 11. Давхар хөдөлмөр эрхэлдэг төгсөгчдийн ажлын байрны хэлбэр /сургуулийн төрөл/


Хэмжих нэгж: хувиар

Ангилал	Цалин хөлстэй ажилтан		Цалин хөлсгүй ажилтан	
	Байнгын	Түр	Ажил олгогч	Хувиараа
ИДС	15,8	53,8	1,0	29,4
МБСБ	7,7	69,1	0,0	23,2
Нийт	14,1	57,0	0,8	28,0

Давхар хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн ажлын байрны хэлбэрийг тодруулвал 71.1 хувь нь цалин хөлстэй ажилтан, 28.8 хувь нь цалин хөлсгүй ажилтан байна. Давхар хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн хувьд ИДС төгсөгчдийн 10 төгсөгч тутмын 5 нь, МБСБ төгсөгчдийн 10 төгсөгч тутмын 7 нь түр ажлын байранд ажиллаж байна. Давхар хөдөлмөр эрхэлж буй ИДС төгсөгчдийн 29.4 хувь нь, МБСБ төгсөгчдийн 23.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж байна.

Зураг 18. Давхар хөдөлмөр эрхэлж буй шалтгаан /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж:хувиар




Төгсөгчдийн 10 хүн тутмын 5 нь цалин орлогоо нэмэгдүүлэхийн тулд, 10 хүн тутмын 2 нь өөрийн хүсэл сонирхлоор болон бусад шалтгаанаар давхар хөдөлмөр эрхэлж байна.

3.2 АЖИЛГҮЙ БАЙГАА ТӨГСӨГЧИД БА ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИГҮЙ БАЙДАЛ

Судалгааны зорилтын нэг хэсэг нь ажилгүй болон эдийн засгийн идэвхигүй байгаа төгсөгчид, тэдгээрийн ажил хайх хэлбэр, ажил хайхад тулгардаг хүндрэл бэрхшээл, ажилгүйдлийн шалтгааныг тодруулах явдал юм. Төгсөгчдийн 30 гаруй хувь нь эдийн засгийн идэвхигүй болон ажилгүй байна. Эмэгтэй төгсөгчдийн эдийн засгийн идэвхигүй байдалд жирэмсэн, төрөх, хүүхэд асрах шалтгаан ихээхэн хувийг эзэлж байна.

2015 онд хөдөлмөр эрхлээгүй байсан ИДС төгсөгчдийн 32.8 хувь нь, МБСБ төгсөгчдийн 41.1 хувь нь 2016 онд ажилгүй хэвээр байна.

Зураг 19. 2015 онд хөдөлмөр эрхлээгүй төгсөгчдийн 2016 оны хөдөлмөр эрхлэлтийн төлөв




2015 онд ажилгүй байсан их дээд сургууль төгсөгчдийн 13.4 хувь нь, МБСБ төгсөгчдийн 9.1 хувь нь 2016 онд хөдөлмөр эрхэлж байна. Өмнөх онд ажилгүй байсан их дээд сургууль

төгсөгчдийн 32.8 хувь нь, МБСБ төгсөгчдийн 41.1 хувь нь ажилгүй хэвээрээ байна. Харин их дээд сургууль төгсөгчдийн 0.9 хувь нь, МБСБ төгсөгчдийн 2.7 хувь нь суралцаж байна.

Зураг 20. 2015, 2016 онуудад ажилгүй байгаа төгсөгчдийн ажилгүй байгаа болон эдийн засгийн идэвхигүй байдлын шалтгаан

Хэмжих нэгж: хувиар




2015, 2016 онуудад ажилгүй байгаа төгсөгчдийн ажилгүйдлийн шалтгааныг тодруулбал 39.4 хувь нь жирэмсэн, хүүхэд, өндөр настан асрах, 27.5 хувь нь эзэмшсэн мэргэжилд тохирох ажил олдохгүй гэх мэт шалтгааныг дурдсан байна.

Хоёр жилийн хугацаанд мэргэжилд тохирох ажил олдохгүйн улмаас ажилгүй байгаа төгсөгчдийг сургуулийн төрөл болон мэргэжлийн чиглэлээр нь ангилан харвал ИДС төгсөгчдийн хувьд бизнесийн удирдлага, багш, боловсрол судлал, хүмүүнлэгийн ухаан, нийгэм, эдийн засаг, хууль эрх зүй, үйлдвэрлэлийн технологи зэрэг мэргэжлийн чиглэлүүд, МБСБ төгсөгчдийн хувьд барилга, барилгын материал үйлдвэрлэл, аж үйлдвэр, ХАА үйлдвэрлэл, геологи, уул уурхай зэрэг мэргэжлийн чиглэлээр төгссөн төгсөгчид нилээдгүй байна. Иймээс хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг хангасан эрэлттэй мэргэжилтэн бэлтгэх нь чухал юм.

2015 онд хөдөлмөр эрхэлж байсан, 2016 онд ажилгүй байгаа төгсөгчдийн ажлаас гарсан шалтгааныг тодруулахад 69.6 хувь нь хувийн шалтгаанаар, 30.4 хувь нь байгууллагаас хамаарсан шалтгаанаар ажлаас гарчээ. Ажлаас гарсан төгсөгчдийн хувийн шалтгааныг тодруулахад 38.7 хувь нь ар гэрийн шалтгаан болох жирэмсэн, хүүхэд өндөр настан асрах, 10.1 хувь нь хувиараа бизнес эрхлэх, 6.8 хувь нь ажилдаа сэтгэл ханамжгүй гэх мэт байна.

Зураг 21. 2015 онд хөдөлмөр эрхэлж байсан, 2016 онд ажилгүй байгаа ажлаас гарсан төгсөгчдийн байгууллагаас хамаарсан шалтгаан /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: хувиар




2015 онд хөдөлмөр эрхэлж байсан, 2016 онд ажилгүй байгаа, ажлаас гарсан төгсөгчдийн байгууллагаас хамаарсан шалтгааны 30.4 хувь нь цалин тогтмол олгодоггүй, 16.7 хувь нь түр ажлын байр байсан, 14.4 хувь нь цалин бага, 11.0 хувь нь орон тооны цомхотголд орсон болон бусад шалтгаанууд байна.

Сургуулийн төрлөөр нь харвал ИДС төгсөгчдийн хувьд цалин тогтмол олгодоггүй, цалин бага, орон тооны цомхотголд орсон гэх мэт шалтгаан түлхүү байгаа бол МБСБ төгсөгчдийн хувьд цалин тогтмол олгодоггүй, түр ажлын байр, байгууллага татан буугдсан зэрэг байгууллагаас хамаарсан шалтгаанаар ажлаас гарчээ.

Зураг 22. Эдийн засгийн идэвхигүй байгаа төгсөгчдийн сүүлийн 30 хоногт ажил хайгаагүй шалтгаан


Хэмжих нэгж: хувиар



Сүүлийн 30 хоногт ажил хайсан эсэхийг тодруулахад төгсөгчдийн 72.9 хувь нь ажил хайсан, 27.1 хувь нь ажил хайгаагүй гэжээ. Төгсөгчдийн 10 төгсөгч тутмын 4 нь ар гэрийн шалтгаан болох хүүхэд, өндөр настан асрах мөн адил 10 төгсөгч тутмын 4 нь ажил олдохгүй гэж бодсон учраас сүүлийн 30 хоногт ажил хайгаагүй байна.

Зураг 23. Ажил хайх хэлбэр, оноор

Хэмжих нэгж: хувиар



Сүүлийн 30 хоногт ажил хайсан төгсөгчдийг гурван жилийн судалгааны үр дүнгээр мэдээллийн эх үүсвэрийг нь харьцуулан харвал хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон хөдөлмөр зуучлалын байгууллагаар үйлчлүүлэх нь дийлэнх хувийг эзэлж байгаа бол хувийн харилцаагаараа дамжуулан ажил хайх нь багасч байгаа дүр зураг ажиглагдаж байна.

Хүснэгт 12. Ажлын байрны сонголт хийхэд чухалчилдаг зүйлс /сургуулийн төрлөөр/


Хэмжих нэгж: хувиар

Хүчин зүйл	Бүгд /дундаж/	ИДС төгсөгч	МБСБ төгсөгч
Нийт	3,8	3,7	3,8
Цалин	4,1	4,1	4,1
Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа	4,1	4,1	4,1
Байгууллагын нэр хүнд	3,8	3,7	3,8
Ажлын чиг үүргийн хүндрэл	3,6	3,6	3,7
Ажлын ачаалал	3,5	3,4	3,6
Өсөн хөгжих боломж	4,2	4,3	4,1
Ажил мэргэжлийн ирээдүй	4,2	4,3	4,2
Ажлын цаг	3,8	3,6	3,9
Ажлын орчин	3,9	4,0	3,9
Ажил, гэр хоорондын зай	3,2	3,0	3,4
Хувийн зан чанарт нийцэх байдал	3,4	3,2	3,6

Ажил хайж байгаа төгсөгчид ажлын байрны сонголт хийхдээ өсөн хөгжих боломж болон ажил мэргэжлийн ирээдүй, цалин, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааг илүү чухалчилж авч үздэг байна. Сургуулийн төрлөөр нь харахад мөн адил эдгээр хүчин зүйлсийн ач холбогдолтой гэж үзжээ.

Зураг 24. Ажил хайх явцад тулгардаг хүндрэл бэрхшээл / 2015, 2016 он /

Хэмжих нэгж:хувиар




Ажил хайх явцад тулгардаг гол бэрхшээлүүд нь ажлын байрны болон ажлын байрны мэдээллийн хомсдол, ажил олгогч танил тал хардаг зэрэг асуудал байна.

2015 онд төгсөгчдийн 17.4 хувь нь ажлын туршлага дутах, 14.9 хувь нь ажлын байрны хомсдол, 2016 онд 25.4 хувь нь ажил олгогч танил тал хардаг, 17.9 хувь нь ажлын байрны хомсдол зэрэг хүчин зүйлс нь ажил хайх явцад түлхүү хүндрэл бэрхшээл учруулдаг гэж үзжээ.

Зураг 25. Эдийн идэвхигүй байгаа шалтгаан


Хэмжих нэгж:хувиар



2016 онд ажилгүй байгаа, ажил хайж байгаа, сүүлийн 7 хоногт ажил хийхэд бэлэн байсан 10 төгсөгч тутмын 4 нь мэргэжилд тохирох ажил олдохгүй, 10 төгсөгч тутмын 2 нь жирэмсэн хүүхэд өндөр настан асрах зэрэг шалтгаанаар түлхүү эдийн засгийн идэвхигүй байна.

Зураг 26. Эдийн засгийн идэвхигүй байгаа төгсөгчдийн ойрын нэг жилийн төлөвлөгөө

Хэмжих нэгж: хувиар




Эдийн засгийн идэвхигүй байгаа төгсөгчдийн ойрын нэг жилийн төлөвлөгөөг нь тодруулахад 10 төгсөгч тутмын 5 нь ажилд орох гэсэн байна. Мөн ажлаа өөрчлөх, суралцах, хувиараа бизнес, аж ахуй эрхлэх зэрэг төлөвлөгөөтэй байна.

БҮЛЭГ 4. СУРГАЛТАНД ХАМРАГДСАН БАЙДАЛ

Төгсөгчдийг сүүлийн нэг жилийн хугацаанд хамрагдсан сургалтын төрөл, дахин суралцаж буй шалтгаан, одоо суралцаж буй мэргэжил болон өмнө эзэмшсэн мэргэжлийн нийцэл зэргийг энэ бүлэгт тодруулахыг зорьсон юм.

Төгсөгчдийг сүүлийн нэг жил хамрагдсан сургалтын хугацаагаар нь богино болон урт хугацааны сургалт гэж хуваан авч үзсэн. Сургалтанд хамрагдагсдын 80.0 хувь нь богино хугацааны, 20.0 хувь нь урт хугацааны буюу мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамрагдсан байна.

Зураг 27. Урт хугацааны мэргэжил эзэмшүүлэх сургалтын төрөл




Урт хугацааны мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамрагдсан төгсөгчдийг сургалтын төрлөөр нь харвал 54.1 хувь нь магистр, докторын зэргийн сургалт, 30.6 хувь нь мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт, 12.4 хувь нь ИДС-д бакалаврын зэргийн сургалтанд хамрагджээ.

Сургалтад хамрагдагсдын ИДС төгсөгчдийн хувьд 63.7 хувь нь магистр, докторын зэргийн сургалт, 32.3 хувь нь мэргэжил дээшлүүлэх сургалтанд, харин МБСБ төгсөгчдийн хувьд 70.7 хувь нь ИДСК-д бакалаврын зэргийн сургалт, 20.4 хувь нь мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтанд тус тус хамрагджээ.


Богино хугацааны сургалтанд хамрагдсан төгсөгчдийг сургалтын төрлөөр нь тодруулбал 75.6 хувь нь ур чадвараа нэмэгдүүлэх сургалт, 13.2 хувь нь гадаад хэлний сургалтанд хамрагджээ.

Зураг 28. Богино хугацааны сургалтын төрөл



Богино хугацааны сургалтанд хамрагдсан төгсөгчдийг сургуулийн төрлөөр нь харвал ИДС төгсөгчдийн 79.4 хувь нь ур чадвараа нэмэгдүүлэх сургалт, 13.6 хувь нь гадаад хэлний сургалтанд хамрагдсан бол МБСБ төгсөгчдийн 65.5 хувь нь мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлэх сургалт, 22.8 хувь нь гадаад хэлний болон амьдрах ухааны сургалтанд тус тус хамрагджээ.


Зураг 29. Дахин суралцаж буй шалтгаан



Төгсөгчдийн дахин суралцаж буй шалтгааныг тодруулахад 10 төгсөгч тутмын 4 нь мэргэжил, мэдлэг, ур чадвар дээшлүүлэх, 10 төгсөгч тутмын 3 нь боловсролын түвшин зэрэг ахиулахаар суралцжээ.

Зураг 30. Суралцаж байгаа мэргэжил болон өмнөх мэргэжлийн нийцэл

Хэмжих нэгж: хувиар



Дахин суралцаж байгаа төгсөгчдийн 6.0 хувь нь өмнөх эзэмшсэн мэргэжлээсээ өөр мэргэжлээр сурч байна. ИДС төгсөгчдөөс дахин бакалаврын зэргийн сургалтанд хамрагдагсдын 42.3 хувь нь өмнө эзэмшсэн мэргэжилтэйгээ бага зэрэг төсөөтэй мэргэжлээр, 24.5 хувь нь огт өөр мэргэжлээр суралцаж байна. Харин магистр, докторын зэргийн сургалтанд хамрагдагсдын 88.8 хувь нь ижил мэргэжлээр суралцаж байна.


Дахин суралцаж байгаа ИДС төгсөгчдийн 24.5 хувь нь огт өөр мэргэжлээр суралцаж байгаа бол МБСБ төгсөгчдийн хувьд 69.6 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ үргэлжлүүлэн, 30.4 хувь нь огт өөр мэргэжлээр бакалаврын хөтөлбөрт суралцаж байна.

БҮЛЭГ 5. ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төгсөгчдийн ойрын нэг жилийн хугацааны ажил, амьдралын төлөвлөгөө, цаашид авахыг хүсч буй цалин зэргийг тодруулахыг зорьсон юм.

Зураг 31. Төгсөгчдийн ойрын нэг жилийн төлөвлөгөө


Хэмжих нэгж: хувиар



Төгсөгчдийн ирээдүйн хүлээлтийн талаар тодруулахад 30.0 гаруй хувь нь цаашид суралцах, 20.9 хувь нь тодорхой төлөвлөгөө байхгүй, 22.2 хувь нь ажилд орох, ажлаа өөрчлөх төлөвлөгөөтэй гэжээ.

Зураг 32. Суралцах төлөвлөгөөтэй байгаа төгсөгчид сургалтын төрлөөр

Хэмжих нэгж: хувиар



Суралцах төлөвлөгөөтэй байгаа төгсөгчдийн 32.1 хувь нь магистр, докторын зэргийн сургалтанд, 27.6 хувь нь дотоодын их дээд сургуульд элсэн суралцах, 16.8 хувь нь одоо суралцаж буй сургуулиа үргэлжлүүлэн суралцах төлөвлөгөөтэй байна. Сургуулийн төрлөөр нь харвал ИДС-ийн 10 төгсөгч тутмын 4 нь магистр, докторын зэргийн сургалтанд элсэн суралцах бол МБСБ-ийн 10 төгсөгч тутмын 4 нь дотоодын их дээд сургуульд суралцах төлөвлөгөөтэй байна.

Төгсөгчдийн цаашид авахыг хүсч буй цалинг тодруулахад ИДС төгсөгчид дунджаар 1066.4 мянган төгрөг, МБСБ төгсөгчид 799.3 мянган төгрөг авахыг хүсч байгаагаа илэрхийлсэн байна. 2012-2013 оны хичээлийн жилд ИДС болон МБСБ төгсөгчид дунджаар 932.6 мянган төгрөгний цалин авахыг хүсч байна гэжээ.

ДҮГНЭЛТ

2012-2013 оны хичээлийн жилд төгссөн төгсөгчдийг сүүлийн гурван жил мөшгөн судалж гурван оны судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтийг хийлээ.

Төгсөгчдийн 61.6 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд тус үзүүлэлт нь өмнөх оныхоос буурсан байна. 2015 онд ажилгүй байсан төгсөгчдийн 5.4 хувь нь, ажилтай байсан төгсөгчдийн 52.3 хувь нь 2016 онд хөдөлмөр эрхэлж байна. Харин 2015 онд ажилтай байсан төгсөгчдийн 12.4 хувь нь ажилгүй болжээ. Хөдөлмөр эрхэлж байгаа ИДС төгсөгчдийн 10 төгсөгч тутмын 9 нь, МБСБ төгсөгчдийн 10 төгсөгч тутмын 7 нь байнгын ажлын байранд ажиллаж байна.

2016 онд төгсөгчдийн сарын дундаж цалин, орлогын хэмжээ нь 640.2 мянган төгрөг байгаа ба Үндэсний статистикийн хорооны 2016 оны 3-р улирлын мэдээгээр 884.3⁵ мянган төгрөг гэсэн байна. Үүнээс харахад төгсөгчдийн дундаж цалин ҮСХ-оос зарладаг улсын дундаж цалинтай харьцуулахад бага байна. Цалин хөлстэй ажилтны хувьд 81.4 хувь нь хөдөлмөрийн гэрээтэй, 18.6 хувь нь хөдөлмөрийн гэрээгүй байгаа ба хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй төгсөгчдийн 50.5 хувь нь хугацаатай, 49.5 хувь нь хугацаагүй гэрээ байгуулан ажиллаж байна. Хөдөлмөрийн гэрээгүй ажиллаж байгаа төгсөгчдийн дундаж цалин 579.2 мянга байна.

Төгсөгчдөд ажлын байранд гадаад хэлний мэдлэг нь хамгийн их тулгарч буй ур чадварын хомсдолын нэг бөгөөд түүний хэрэгцээ шаардлага жил ирэх тутам нэмэгддэг байна. Түүнчлэн төгсөгчдөд тулгарч буй ур чадварын хомсдолд мэргэжлийн ур чадвар, багаар ажиллах чадвар зэрэг нь нилээдгүй хувийг эзэлсээр байна. Харин шинжлэх ухаан технологийн мэдлэг, мэдээллийн технологийг ашиглах, эзэмших зэрэг ур чадварууд нь ажлын байранд гарсан эхний жил тодорхой хувийг эзэлдэг ч, хугацаа өнгөрөх тусам дутагдах ур чадварт орох хувь нь багасч байна.

Мэргэжлээрээ түлхүү ажиллаж байгаа мэргэжлийн чиглэлүүд нь ИДС төгсөгчдийн хувьд сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгүүл ба мэдээлэл, биологи, мал эмнэлэг, анагаах ухаан, цагдаа аюулгүй байдал, МБСБ төгсөгчдийн хувьд захиргаа үйлчилгээний ажилтан, тээвэр зэрэг мэргэжлийн чиглэлүүд байна. Харин мэргэжлээрээ төдийлөн ажиллаж чадахгүй байгаа мэргэжлийн чиглэлүүдэд ИДС төгсөгчдийн хувьд нийгмийн халамж, хамгаалал, ХАА, ОАА, ЗАА, хүмүүнлэгийн ухаан, бизнес ба мэдээлэл, МБСБ төгсөгчдийн хувьд ОАА мод боловсруулах салбар, ХАА үйлдвэрлэл, мэдээллийн технологи зэрэг чиглэлүүд байна. Цаашид мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн шалтгааныг нь тодруулан, ХЗЗ-ийн тухайн мэргэжлийн ажлын байрны хомсдол уу, эсхүл төгсөгчийн ур чадварын дутагдал эсэхийг судлах шаардлагатай юм.

Төгсөгчдийн ажил эрхлэлтийн ирээдүйн төсөөлөл их чухал бөгөөд хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн тогтвортой ажиллах эсэх талаар тодруулахад 81.6 хувь нь тогтвортой ажиллана, 18.4 хувь нь ажлын байранд үлдэх сонирхолгүй байгаагаа илэрхийлсэн. Ажлын байрандаа үлдэх сонирхолгүй байгаа төгсөгчдийн шалтгааныг тодруулахад МБСБ төгсөгчдийн хувьд түр ажлын байр, сурах хүсэлтэй, мэргэжлээрээ ажиллах сонирхолтой гэсэн бол, ИДС төгсөгчдийн хувьд илүү хөгжих боломжтой, нөхцөл сайтай ажил хийх, түр ажиллаж байгаа, мэргэжил мэдлэг нь ур чадварт тохирдоггүй зэрэг шалтгаануудыг дурдсан байна.

⁵ ҮСХ МУ-ын нийгэм, эдийн засгийн байдал I-XI сар, аж ахуй нэгж байгууллагын ажиллагчдын нийт цалингийн дундаж 884.3 мянган төгрөг

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдөөс ажлын байрны мэдээллийн эх сурвалжийг тодруулахад нийт төгсөгчдийн ихэнх нь эцэг эх, хамаатан садан, найз нөхөд болон хамт суралцагсдаасаа буюу хувийн харилцаагаар дамжуулан авдаг нь түгээмэл байна. Гэхдээ гурван оны судалгааны үр дүнгээс харахад төгсөгчид ажил хайхдаа ажлын байрны мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон хөдөлмөр зуучлалын байгууллагаар үйлчлүүлэх нь харьцангуй нэмэгдэж, хувийн харилцаагаар дамжуулан ажил хайх хувь багасч байгаа нь ажиглагдсан.

2015 онд хөдөлмөр эрхлээгүй байсан ИДС төгсөгчдийн 32.8 хувь нь, МБСБ төгсөгчдийн 41.1 хувь нь 2016 онд ажилгүй хэвээр байна. Харин их дээд сургууль төгсөгчдийн 0.9 хувь нь, МБСБ төгсөгчдийн 2.7 хувь нь суралцаж байна. 2015, 2016 онуудад ажилгүй байгаа төгсөгчдийн ажилгүйдлийн шалтгааныг тодруулбал 39.4 хувь нь жирэмсэн, хүүхэд, өндөр настан асрах, 27.5 хувь нь эзэмшсэн мэргэжилд тохирох ажил олдохгүй гэх мэт шалтгааныг дурдсан байна. Эзэмшсэн мэргэжилд тохирох ажил олдохгүйн улмаас ажилгүй байгаа төгсөгчдийг сургуулийн төрөл болон мэргэжлийн чиглэлээр нь харвал ИДС төгсөгчдийн хувьд бизнесийн удирдлага, багш, боловсрол судлал, хүмүүнлэгийн ухаан, нийгэм, эдийн засаг, хууль эрх зүй, үйлдвэрлэлийн технологи зэрэг мэргэжлийн чиглэлүүд, МБСБ төгсөгчдийн хувьд барилга, барилгын материал үйлдвэрлэл, аж үйлдвэр, ХАА үйлдвэрлэл, геологи, уул уурхай зэрэг мэргэжлийн чиглэлээр төгссөн төгсөгчид нилээдгүй байна.

2015 онд хөдөлмөр эрхэлж байсан, 2016 онд ажилгүй байгаа төгсөгчдийн 69.6 хувь нь хувийн шалтгаанаар, 30.4 хувь нь байгууллагаас хамаарсан шалтгаанаар ажлаас гарчээ. Ажлаас гарсан төгсөгчдийн хувийн шалтгааны ихэнхи нь жирэмсэн, хүүхэд өндөр настан асрах зэргийг дурдсан байна. Харин байгууллагаас хамаарсан шалтгааныг цалин бага эсхүл тогтмол олгодоггүй, түр ажлын байр байсан, орон тооны цомхотгол зэргийг дурджээ.

Ажил хайж байгаа төгсөгчид ажлын байрны сонголт хийхдээ өсөн хөгжих боломж болон ажил мэргэжлийн ирээдүй, цалин, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааг илүү чухалчилж авч үздэг байна. Ажил хайх явцад тулгардаг гол бэрхшээлүүд нь ажлын байрны болон ажлын байрны мэдээллийн хомсдол, ажил олгогч танил тал хардаг зэрэг асуудал байна.

Төгсөгчдийг сүүлийн нэг жилийн хугацаанд хамрагдсан богино болон урт хугацааны сургалтанд 25.8 хувь нь хамрагдсан байна. Харин сургалтанд хамрагдагсадын таван хүн тутмын 4 нь богино хугацааны, 1 нь урт хугацааны буюу мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамрагджээ. Урт хугацааны мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамрагдсан төгсөгчдийн хувьд талаас илүү хувь нь магистр, докторын зэргийн сургалтад, гурван хүн тутмын бараг нэг нь мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтад, арван хүн тутмын нэг нь ИДСК-д бакалаврын зэргийн сургалтанд хамрагджээ. Богино хугацааны сургалтанд хамрагдсан төгсөгчдийн хувьд ур чадвараа нэмэгдүүлэх, гадаад хэлний сургалтанд хамрагджээ.

Төгсөгчдийн ирээдүйн хүлээлтийн хувьд гурван хүн тутмын нэг нь цаашид суралцах, таван хүн тутмын нэг нь ажилд орох төлөвлөгөөтэй байгаагаар дурдсан байна. Тодорхой төлөвлөгөө байхгүй төгсөгчид ч нэлээд хувийг эзэлж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- ✓ Судалгаанаас харахад төгсөгчдийг 10 жилийн сургууль төгсөхөөс өмнө мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрт хамруулах, мэргэжил сонголтод нь анхаарах хэрэгтэй байна. Мэргэжил сонголтоо зөв хийгээгүйгээс ажил олдохгүй байх, цаг хугацаа алдах болон үргүй зардал их гарч байна.
- ✓ Төгсөгчдийн ажлын байран дахь анхны жилийн ур чадварын хомсдолд багаар ажиллах чадвар, мэдээллийн технологи ашиглах чадвар, харилцааны ур чадварууд давамгайлдаг байна. Харин хөдөлмөр эрхлэлтийн дөрвөн жилийн явцад гадаад хэлний мэдлэг, математик сэтгэлгээ, мэдээллийн технологи ашиглах ур чадварууд илүүтэй хомсдог гэжээ. Өөрөөр хэлбэл энэ төрлийн сургалтын хөтөлбөрийг өргөжүүлэх шаардлагатайг илэрхийлж байна. Түүнчлэн ажил олгогчдын шаардаж буй ур чадварын талаар тусгайлсан судалгаа хийж, сургалтын хөтөлбөрөө баяжуулах.
- ✓ МБСБ төгсөгчдийн хувьд түр болон улирлын чанартай ажлын байранд ажиллах тохиолдол ИДС төгсөгчдөөс 4 дахин их байдгаас үүдэлтэй нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдахгүй байх, хөдөлмөрийн гэрээгүй ажиллах зэрэг тохиолдлууд харьцангуй ажиглагддаг тул сургалтын хөтөлбөрт хөдөлмөрийн тухай хууль, эрхзүйн асуудлыг сайтар сурталчлах хэрэгтэй юм.
- ✓ Мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн шалтгааныг нь тодруулан, хөдөлмөрийн зах зээлийн тухайн мэргэжлийн ажлын байрны хомсдол уу, эсхүл төгсөгчийн ур чадварын дутагдал эсэхийг тодруулах шаардлагатай юм.
- ✓ Ажилгүйдэл болон эдийн засгийн идэвхигүй байдлын шалтгааныг тусгайлан судлах зайлшгүй шаардлагатай байна.
- ✓ Мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа шалтгааны улмаас ажил хийхгүй байгаа төгсөгчдийн мэргэжлийн чиглэл, ажлын байрны захиалгын мэдээлэлд дүн шинжилгээ хийх.
- ✓ Жил бүрийн төгсөгчдийн 50 хувийг бизнес удирдлага, багш боловсрол судлал, анагаах ухааны мэргэжлийн чиглэлийн төгсөгчид эзэлж байгаа бөгөөд эдгээр мэргэжлийн хөдөлмөрийн зах зээлийн шингээлтийг судлах.